



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 11649


Арвайхээр

Нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4.a, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- Хужирт суманд баригдаж байгаа 75 ортой цэцэрлэгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Юу Зэт Эрдэнэ” ХХК-ийн гүйцэтгэж буй ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй гадна тохижилтын (блокон хашаа, төмөр хашаа, сүүдрэвч, сандал, явган хүний зам) ажлуудыг нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээгээр гүйцэтгүүлсүгэй.
- Нэмэлт гэрээ байгуулж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-д даалгасугай.
- Нэмэлт ажилд шаардагдах 67 000 711 (жаран долоон сая долоон зуун арван нэг) төгрөгийг Сангийн яаманд уламжлан тендерийн үнийн зөрүү зардлаас шийдвэрлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101219

D:My Doc. Zahiramj. Zasag darga